

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын ЕБС-ийн сургууль, сургуулийн дотуур байр, спорт заалны засварын ажил

А. Ажлыг гүйцэтгэх хугацааны график /хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоо/-ийг тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.

Б. Соёлын төвийн барилгын засварын ажлыг Барилгын норм ба дүрэм /БНБД/, стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх

В. Үнийн саналд зураг төсвийн үнийг 3 000 000 /Турван сая/ төгрөгөөр тооцох, захиалагчийн хяналтын зардлыг Барилга усралтын ажлын төсөвт өртгийн дүнгийн 2%-иар, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн хяналтын зардлын 50%-иар тооцож тусгаж ирүүлнэ.

Г. Талбайн зохион байгуулалтын зураг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах төслийн баримт бичгийг тухайн ажилд нийцүүлэн боловсруулах

Д. Барилгын их засварын ажлыг дулааны улиралд гүйцэтгэнэ.

1. Дээврийн ажил

- Дээврийн ажлыг гүйцэтгэхдээ БНБД 31-02-03, БНБД 31-07-05, БНБД 31-08-05 бусад норм, стандартыг мөрдлөг болгоно.

-Сургууль болон дотуур байрны хуучин хар цаас болон цементэн тэгшилгээг задалж бүрэн буулгаж цэвэрлэсний дараа дээвэрт бетон тэгшилгээг 15см-ийн зузаантай хийнэ. Бетонон тэгшилгээн дээр хөрсжүүлэгч түрхэж 1 үе чулуугүй, 1 үе чулуутай хар цаас наана. Хар цаасны амыг зориулалтын ам дарагч түрхэгээр түрхэж өгөхийг анхаар. Мөн прапетны төмрийг шинэчлэн сольж, дээврийн ус урсгагч ховилыг цайрдсан гөлмөн төмрөөр солино.

2. Хаалга цонхны ажил

- Хаалга, цонхны ажилд БНБД 81-55-05, MNS 5803:2008 дагуу гүйцэтгэх ба цонхны амалгааны ажилд БНБД 3.04.02-88-г мөрдөнө.

- Цонхыг захиалахдаа талбай дээр нүхний хэмжээг дахин нарийвчлан хэмжих шаардлагатай.

- ЕБС, дотуур байр, спорт заалны хуучин хаалга, цонхыг бүрэн буулгаж, зураг төсөлд тусгагдсаны дагуу, техникийн тодорхойлолтын шаардлага хангахуйц, сайн чанарын хаалга, цонхыг заагдсан төслийн байриудад тус тус угсарна.

- Цонх хаалганы завсрыг шүршдэг хөөсөөр сайтар битүүмжилсний дараа амалгаа шавардлагыг нямбайлан хийнэ. Мөн цонхонд мозайкин тавцан суулгана.

- Хаалга, цонхыг эрх бүхий байгууллагаар хийлгэж угсруулах эсвэл импортын материал худалдан авах тохиолдолд чанартай бат бөхийг сонгон хэрэглэх шаардлагатай.

3. Дотор заслалын ажил

- Дотор хуурай ба нойтон шавардлага, будаг, цааслалт, шиллэгээ, өнгөлгөөний ажилд Заслалын ажил /БНБД 31-10-05/-г мөрдлөг болгоно. Заслалын ажилд хэрэглэх материалууд нь MNS5252:2003, MNS4584:98, MNS4581:2003 техникийн шаардлагыг хангасан байна.

- Гадна агаарын температур +8 хэмээс багагүй, өрөөний температур +10 хэмээс багагүй үед заслалын ажлыг гүйцэтгэнэ.

- Цонхны амалгааны засварын ажил БНБД 3.04.02-88-г мөрдөнө.

- Хаалга, цонхны ажилд БНБД 81-55-05, MNS5803:2008 дагуу гүйцэтгэх ба модон эдэлхүүний материалд улсын стандарт MNS3944:1998-г мөрдөнө.

- Шалны ажилд БНБД 3.04.04-90, БНБД 81-11-06 мөрдлөг болгоно.

- ЕБС, дотуур байр, спорт заалны өрөө тасалгааны хуучин хаалга, хулдаасан шал зэргийг төсөвт тусгагдсаны дагуу задалж буулган, хуучин хана, таазны гадаргууг сайтар хусаж цэвэрлэн технологийн дагуу бэлтгэсний дараа сайн чанарын тэгшилгээ хийж өгнө.

- Спорт заалны хуучин банзан шалны хөдөлгөөнд орсон хэсгүүдийг сайтар бэхэлж, өмхөрсөн банзыг хуулж шинэчлэн, нийтэд нь хөдөлгөөнгүй болгон битүүмжилсний дараа 60см-ын алхамтайгаар 5см*7см-ын харьцаатай прүс модоор дай зангидаж түүн дээр уур ус тусгаарлагчийг дэвсэж, хар паннер шрулдэж бэхэлсний дараа заалны шалны зориулалттай рейк модон шалыг шахаж хийнэ. Дай болон хуучин модон шалны дунд зориулалтын чийргэвч резин жийргэлж өгөхийг анхаар.

- Тус барилгуудын хана, тааз, шалны будаг, эмульсийг сонгохдоо хүүхдийн эрүүл ахуйд бүрэн нийцсэн үнэргүй, хар тугалгын орц бага байх шаардлагатайг анхаар.

-Шинээр хийх гантгиг чулуун хавтан шал, вааран хавтанцар шал, хулдаасан шал, хаалга, хана, шалны будаг зэргийн өнгөний зохицол хоорондоо тохиромжтой байх бөгөөд өнгө үзэмж, чанар сайтайг сонгон хэрэглэнэ.

- Өрөө тасалгааны өнгөний сонголтыг хийхдээ захиалагч, ашиглагч байгууллагатай харилцан зөвшилцөх шаардлагатай.

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

1. Барилгын засварын ажлыг батлагдсан зураг төсөл, ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
2. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
3. Барилгын засварын ажлыг эхлүүлэхдээ иргэдийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулах, хашаа барих зэрэг шаардлагатай арга хэмжээг авч гэнэтийн аюул осол гаргахгүй байхаар ажиллана.
4. Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүн, үнийн баримтыг хавсаргана.
5. Барилгын талбайд ажлын журнал, батлагдсан зураг төсөл, хэрэглэгдэж буй материалын лабораторийн сорилтын дүн, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн бичиг баримтуудыг бэлэн байлгах шаардлагатай.
6. Барилгын засварын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.

7. Барилгын зураг төсөлд зааснаас зайлшгүй тохиолдолд өөрчлөлт оруулах болвол захиалагч болон зураг төслийн байгууллагатай зөвшилцөнө. Зөвшөөрөлгүйгээр газар дээр өөрчлөхийг хориглоно.
8. Барилгын тухай хуулийн 14.3-т заасны дагуу ашиглалтанд хүлээлгэн өгснөөс хойш зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна. Энэ хуулийн 14.6 заасны дагуу 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хий, бүтээц, цэвэр бохир ус,уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна.
9. Гүйцэтгэсэн ажлыг ил, далд ажлын акт, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.
10. Хэрвээ барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 7 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зураг төсвийн дагуу гүйцэтгэнэ.
11. Гүйцэтгэгч нь барилгын ажлын ил, далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг бүрэн биелүүлнэ.
12. Энэхүү техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.
13. Үнийн саналд Барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 181 тоот тушаалын дагуу нэмэгдэл зардал, төлөвлөгөөг ашиг, техник хяналт, нормчлолын сан, НӨАТ, магадлашгүй ажлын зардал зэргийг тооцож Барилгын төсөв зохиох дүрэм БНБД "ҮҮ" 81-95-12-г мөрдлөг болгоно.
14. Үнийн тарифийг тооцон ирүүлэхдээ ажилбар тус бүрээр тооцож ирүүлнэ.

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

ДОТУУР БАЙРНЫ ДЭЭВРИЙН ИХ ЗАСВАР

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Хуйлмал материалан дээвэр буулгах	м2	360
2	Цементэн тэгшилгээ задлах	м2	360
3	Дээврийн 15мм зузаан цементэн тэгшилгээ хийх	м2	360
4	Дараагийн 1мм зузаан тутамд үнэлгээ 30-д нэмэх	м2	3600
5	Дээврийн бетон ба зуурмаг тэгшилгээн дээр ус тусгаарлах үеийн хөрсжүүлэлт хийх	м2	360
6	Хуйлмал хар цаасан дээвэрт чулуугүй хар цаас наах	м2	360
7	1үе хар цаасан дээр чулуутай хар цаас давхарлан бүрж наах	м2	360
8	Парпет төмөр шинэчлэн солих	м2	26
9	Дээврийн ус урсгалч ховилыг цайрдсан гелмен төмрөөр солих	м	60
10	Барилгын хог цэвэрлэх	м2	80

ДОТУУР БАЙРНЫ ХААЛГА, ЦОНХНЫ ЗАСВАР

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Цонхны хайрцаг задлах	хайрцаг	40
2	Вакум цонх угсрах	м2	85.86
3	Цонхны зай завсрыг баллонтой шүршдэг хөөсөөр чигжиж дулаалах	м2	85.86
4	Хаалга буулгах	м2	91.07
5	Дотор тосгон хананд хаалга усрах	м2	75.39
6	2м2 хуртэл талбайтай бүргэд хаалга суулгах	ш	8
7	Хаалганд цоож суулгах	ш	35
8	Хаалганы зай завсрыг баллонтой шүршдэг хөөсөөр чигжих	м2	91.07
9	Хаалга өнгийн тосон будгаар гар аргаар ердийн будах	м2	75.39
10	Цонх хаалганы амалгааны шаарын засвар	м2	176.93
11	Цонхны усны хаялга тавцанг цайрдмал төмрөөр хийх	м	62
12	Цонхны мозайкин тавиур хавтан суулгах	м2	32
13	Хуучин будагтай дотор ханын гадаргууг багсаар будах	м2	76.93

ДОТУУР БАЙРНЫ ДОТОР ЗАСВАР

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Хуучин будагтай ханын гадаргууг хусаж цэвэрлэх	м2	190
2	Хуучин будагтай таазны гадаргууг хусаж цэвэрлэх	м2	657.82
3	Хуучин будагтай дотор ханын гадаргууг багсаар будах	м2	1108.91
4	Тааз усан цийдэм будгаар өнхрүүлгээр өндөр чанартай будах	м2	657.82
5	Шал өнгийн тосон будагаар гар аргаар сайн чанартай будах	м2	657.82
6	Хуучин будагтай төмөр хөвөт, сантехникийн хэрэгсэлүүд бусад төмөр гадаргууг 2 удаа өнгө хувиргасан будгаар будах	м2	55

СУРГУУЛИЙН ДЭЭВРИЙН ЗАСВАР

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Хуйлмал материалан дээвэр буулгах	м2	575
2	Цементэн тэгшилгээ задлах	м2	575
3	Дээврийн 15мм зузаан цементэн тэгшилгээ хийх	м2	575
4	Дараагийн 1мм зузаан тутамд үнэлгээ 30-д нэмэх	м2	5750

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

5	Дээврийн бетон ба зуурмаг тэгшилгээн дээр ус тусгаарлах үеийн хөрсжүүлэлт хийх	м2	575
6	Хуйлмал хар цаасан дээвэрт чулуутай хар цаас наах	м2	575
7	1үе хар цаасан дээр чулуутай хар цаас давхарлан бүрж наах	м2	575
8	Парпет төмөр шинэчлэн солих	м2	26
9	Дээврийн ус урсгагч ховилыг цайрдсан гөлмөн төмрөөр солих	м	90
10	Барилгын хог цэвэрлэх	м2	120

СУРГУУЛИЙН ХААЛГА, ЦОНХНЫ ЗАСВАР

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Цонхны хайрцаг задлах	хайрцаг	49
2	Вакум цонх угсрах	м2	152.3
3	Цонхны зай завсрыг баллонтой шүршдэг хөөсөөр чигжиж дулаалах	м2	152.3
4	Хаалга буулгах	м2	71.8
5	Дотор тоосгон хананд хаалга усрах	м2	66.8
6	2м2 хүртэл талбайтай бүргэд хаалга суулгах	ш	2
7	Хаалганд цоож суулгах	ш	27
8	Хаалганы зай завсрыг баллонтой шүршдэг хөөсөөр чигжих	м2	71.8
9	Хаалга өнгийн тосон будгаар гар аргаар ердийн будах	м2	66.8
10	Амалгааг өндөр чанартай шавардах	у/м	374.4
11	Цонхны усны хаялага тавцанг цайрдмал төмрөөр хийх	м	84.6
12	Цонхны мозайкин тавиур хавтан суулгах	м2	49.22

СУРГУУЛИЙН ДОТОР ЗАСВАР

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Хуучин будагтай ханын гадаргууг хусаж цэвэрлэх 50%	м2	489
2	Хуучин будагтай таазны гадаргууг хусаж цэвэрлэх 50%	м2	882
3	Хана таазны хуурай шавардлагыг ховхлож унагах	м2	100
4	Хуучин будагтай дотор ханын гадаргууг багсаар будах	м2	882
5	Тааз усан цийдэм будгаар өнхрүүлгээр өндөр чанартай будах	м2	489
6	Шал өнгийн тосон будагаар гар аргаар сайн чанартай будах	м2	750
7	1-р давхарт коридор, вестибюль, өлгүүрийн өрөөнд цементэн зуурмаг дээр вааран хавтанцар наах	м2	197.5
8	Тамбурт гантиг чулуун хавтан дэвсэж шал хийх	м2	11.8
9	Шатны гишгүүрийг эргэх давцангийн хамт өнгөлсөн гантиг хавтангаар өнгөлөх 25мм	м2	18.6
10	Хуучин будагтай төмөр хавтас, сантехникийн хэрэгсэлүүд бусад төмөр гадаргууг 2 удаа өнгө хувиргасан будгаар будах	м2	55
11	Таазны 10м2 хүртэл талбайтай бетонон гадаргууд шаврын засварыг шохой-цементэн зуурмагаар хийх	м2	100

СПОРТ ЗААЛНЫ ХААЛГА, ЦОНХНЫ ЗАСВАР

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Цонхны хайрцаг задлах	хайрцаг	12
2	Вакум цонх угсрах	м2	8.5
3	Цонхны зай завсрыг баллонтой шүршдэг хөөсөөр чигжиж дулаалах	м2	8.5
4	Хаалга буулгах	м2	13.2
5	Дотор тоосгон хананд хаалга усрах	м2	10.1

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

6	Гадна дулаалгатай төмөр хаалга суулгах	ш	1
7	Хаалганд цоож суулгах	ш	7
8	Хаалганы зай завсрыг баллонтой шүршдэг хөрсөөр чигжих	м2	13.2
9	Хаалга өнгийн тосон будгаар гар аргаар ердийн будах	м2	10.1
10	Амалгааг өндөр чанартай шавардах	у/м	48
11	Цонхны усны хаялага тавцанг цайрдмал төмрөөр хийх	м	18.3
12	Цонхны мозайкин тавиур хавтан суулгах	м2	12.8
13	Шилэн гулдмайгаар цонх өрөх	м2	30.2

СПОРТ ЗААЛНЫ ДОТОР ЗАСВАР

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Хуучин будагтай ханын гадаргууг хусаж цэвэрлэх	м2	580
2	Хуучин будагтай таазны гадаргууг хусаж цэвэрлэх	м2	180
3	Шалны хуучин хулдаас линолеум хуулах	м2	11
4	Хуучин будагтай дотор ханын гадаргууг багсаар будах	м2	580
5	Тааз усан цийдэм будгаар өнхрүүлгээр өндөр чанартай будах	м2	250
6	Коридор, агуулхын өрөөнд цементэн зуурмаг дээр вааран хавтанцар наах	м2	15
7	Хүйтэн түрхлэг дээр хулдаас нааж шал хийх	м2	11
8	Хуучин шалыг бэхлэж хөдөлгөөнгүй болгож, шалны дээр жийргэвчтэй, 5*7 приус модоор 600x600 хэмжээтэй рам зангидаж тэгшилгээ хийх	м2	181
9	Мод хавтангаар дэвсгэр шал хийж тэгшилгээ хийх	м2	181
10	29 мм -н зузаан зориулалтын рейх модон шал шахах	м2	181
11	Будаггүй модон шалыг 2 үе ланцах	м2	10.3
12	Тамбурт гантиг чулуун хавтан дэвсэж шал хийх	м2	11.5
13	Хуучин будагтай төмөр хавтас, сантехникийн хэрэгсэлүүд бусад төмөр гадаргууг 2 удаа өнгө хувиргасан будгаар будах	м2	11.5